

МЭНДЧИЛГЭЭ

Ханбогд сумын Засаг захиргаа, Малчид болон “Оюу толгой” ХХК-ийн төлөөллөөс бүрдсэн Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн гишүүдийн өмнөөс та бүхэнтэй энэхүү Орон нутгийн сонины тусгай дугаараар мэндчилж байгаагаа таатай байна.

2017 оны 5 сарын 9-нд Ханбогд сумын ирээдүйн тогтвортой хөгжилд, Ханбогдын малчин иргэдийн тогтвортой амьжиргаанд чухал хувь нэмэр болох үйл явдал болж өнгөрлөө. Энэ бол Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн гишүүдийн өнгөрсөн дөрвөн жилийн хамтын хичээл зүтгэл, хамтын ажлын үр дүнд Малчдын гомдлыг барагдуулах гэрээг байгуулж, гарын үсэг зурлаа. Энэхүү гэрээ нь зөвхөн хэсэг малчдын гомдлыг барагдуулахад төдийгүй, сум орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах, уурхайн үр өгөөжийг тогтвортой хөгжилд шингээж үлдээх их ажлын гараа боллоо гэж бид дүгнэж байна.

Та бүхэн энэ тусгай дугаараас Талуудын байгуулсан Малчдын гомдол барагдуулах гэрээнүүд болон Нөхөн олговрын нэхэмжлэлийн хорооны журамтай танилцаарай.

Ханбогд сумын малчин иргэд олон нийт Гурван талт зөвлөлийг байгуулагдсан цагаас эхлэн ямар хүмүүс юу хийж байгааг анхааран ажиглаж, олон удаагийн яриа хэлэлцээнээс гарах үр дүн чих тавин хүлээж суусан байх. Өнөөдөр бид ажлын үр дүнгээ та бүхэнд танилцуулж байна. Орон нутгийн удирдлагууд, малчин иргэд, компанийн төлөөлөл бүгд хамтарч ажиллаж чадсанаар хэн ч чамлахгүй үр дүнтэйгээр олон талын хөдөлмөр, сэтгэл зүтгэл шингэсэн Гэрээг байгууллаа. Маргаашнаас бид марган мэтгэлцэхэд биш харин төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлэхэд анхаарч хамтын ажиллагаагаа үргэлжүүлнэ.

Өнөөдрийн үр дүнд хүрэхэд хамтран ажилласан бүх хүмүүс байгууллагуудад гүн талархал илэрхийлье.

Энэ ажлыг анхлан санаачилж хамтран өдий зэрэгт тууштай зүтгэсэн Малчдын төлөөлөл, зөвийг зөвтгөж, бурууг буруутгаж дэмжин ажилласан Орон нутгын засаг захиргаа, уул уурхай хөгжиж буй бүс нутгийн малчдынхаа гомдол саналыг эн тэргүүнд авч хэлэлцэж шийдвэрлэж байгаа Оюу Толгой компаны удирдлагууд, бүгдэд талархал дэвшүүлж амжилт хүсье. Зөвлөлийн яриа хэлэлцээг маш амжилттай хөтлөн чиглүүлж, сэтгэл санаа, цаг заваа зориулан ажилласан Эрх зүйн нийцэл хяналт зөвлөгөө Омбудсманы газрын хамт олондоо маргааныг шийдвэрлэхэд их тус хүргэсэнд талархал дэвшүүлье

Бидний энэ ажил олон ашиг сонирхлыг төлөөлсөн талууд ширээний ард суугаад, амжилтанд хүрч болдог гэдгийг харуулах жишиг, туршлага болох байх гэж найдаж байна. Бидний өмнө их ажил хүлээж байна. Малчдын гомдол барагдуулах гэрээнд тусгасан ажил нэг бүрийг хэрэгжүүлэхэд Ханбогдын малчин иргэдийн идэвхтэй оролцоо ихээхэн чухал үүрэгтэй гэдгийг онцлон хэлье. Гэрээний үүргээ хэрэгжүүлж ажиллахад Зөвлөлд нэгдсэн талууд анхааран ажиллах болно.

Гурван талын хамтын ажиллагаа бүтэмжтэй үйлс өөдрөг байх болтугай.

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн Удирдах нэгж

Ж.Занабазар

Л.Батцэнгэл

О.Цэрэннадмид

Ханбогд сумын Засаг даргын орлогч

Говийн Газар Шороо ТББ-ийн тэргүүн, Жавхлант баг

Орон нутгийн түншлэл, тусламжийн менежер